

**ИРГЭД ХАРИЛЦАН ВИЗГҮЙ ЗОРЧИХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ
БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар,

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны болон харилцан туслалцах тухай Гэрээний дагуу найрамдалт харилцаагаа цаашид хөгжүүлэх хүсэл эрмэлзлэлийг удирдлага болгон, хоёр улсын иргэдийн зорчих журмыг боловсронгуй болгох үүднээс,

Энэхүү Хэлэлцээрийг байгуулахаар шийдвэрлэж, дор дурдсан зүйлийн талаар хэлэлцэн тохиролцов. Үүнд:

Ерөнхий заалт

1 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт үндэснийхээ хүчин төгөлдөр паспорттай орж, гарч, дамжин өнгөрч, түр хугацаагаар байж болно.

2 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт дурдсан үндэсний паспорт гэж дорхи паспортыг хэлнэ:

- дипломат паспорт;
- албан паспорт;
- энгийн гадаад паспорт;
- гадаад паспорт /хувийн хэргээр зорчигчдод олгох/;
- БНМАУ-д буцах үнэмлэх;

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын иргэний хувьд:

- дипломат паспорт;
- албан паспорт;
- энгийн гадаад паспорт;
- усан цэргийн паспорт /зорчих зорилго, хаа хүрэхийг тэмдэглэсэн/;
- ЗСБНХУ-д буцах үнэмлэх;

Гуравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа тухайн Талын хууль, дүрэм, түүний дотор гадаадын иргэд бүртгүүлэх, оршин суух болон шилжин явах журмыг сахих үүрэгтэй.

2. Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэхүү Хэлэлцээрийн дагуу өөрийн иргэдийг явуулахдаа бүртгүүлэх, оршин суух, шилжин явах үндсэн журам, түүнчлэн гаалийн болон валютын хууль дүрмийн тухай тэдэнд мэдээлж байхын дээр хэрэгцээтэй гэж үзвэл зохих санамж хуудас олгоно. Энэ зорилгоор Хэлэлцэн

тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллагууд шаардагдах мэдээллийг харилцан солилцоно.

Албан хэргээр зорчих

4 дүгээр зүйл

1. Харьяат улсынхаа нутаг дэвсгэрт байнга оршин суугаа бөгөөд албан хэргээр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт очих Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн болон түүнтэй адил харьяалал бүхий гэр бүлийнх нь гишүүд албан томилолтын хугацаанд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт тухайн Талын визгүйгээр үндэснийхээ паспорттай орж, гарч, түр хугацаагаар байж болно.

2. Хэрэв Хэлэлцэн тохиролцогч Талын иргэн дипломат буюу албан паспорттай, түүний гэр бүлийн гишүүд нь үндэсний өөр төрлийн паспорттай явбал уг иргэдийг харьяалах Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллага тэдний паспорт /буюу хавсралт/-д зохих тэмдэглэл хийнэ.

3. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн нь нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч Талын нэг удаагийн буюу олон удаагийн албан виз бүхий үндэснийхээ паспорттайгаар бие дааж буюу гэр бүлийн гишүүний хувьд харьяат улсынхаа нутаг дэвсгэрт албан хэргээр зорчиж болно.

Солилцооны хүрээнд зорчих

5 дугаар зүйл

1. Харьяат улсынхаа нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн улс, олон нийтийн байгууллага хоорондын солилцооны хүрээнд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт визгүйгээр үндэснийхээ паспорттай зорчиж болно.

2. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн улс, олон нийтийн байгууллага хоорондын солилцооны хүрээнд нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч Талын виз бүхий үндэснийхээ паспорттайгаар харьяат улсынхаа нутаг дэвсгэрт зорчиж болно.

Жуулчнаар зорчих

6 дугаар зүйл

1. Харьяат улсынхаа нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн жуулчлалын бичиг баримттай бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр үндэснийхээ паспорттай жуулчилж болно.

2. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн жуулчлалын бичиг баримт болон нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч Талын гарах-орох визтэй бол үндэснийхээ паспорттайгаар харьяат улсынхаа нутаг дэвсгэрт жуулчилж болно.

7 дугаар зүйл

Жуулчлалын нөхцөл /хугацаа, аялал чиглэл гэм мэт/ болон жуулчлалын бичиг баримтын маягтыг Хэлэлцэн тохиролцогч Талуудын жуулчлалын байгууллагууд тодорхойлно.

Жуулчлалын бичиг баримтын хүчин төгөлдөр байх хугацаа нь үндэсний паспортын хүчин төгөлдөр байх хугацаанаас хэтэрч үл болно.

8 дугаар зүйл

Жуулчдын хэсгийн бүрэлдхүүнд орж Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ирсэн бөгөөд ямар нэгэн шалтгаанаар хэсгээсээ хоцорсон Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн аялалаа үргэлжлүүлж буюу нөгөө Талын нутаг дэвсгэрээс түүний дүрмийн дагуу гарч явж болно.

Хувийн хэргээр зорчих

9 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэд нутаг дэвсгэрт нь очих Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллагаас олгосон урилгын гэрчилгээтэй бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа төрөл садныдаа буюу танилындаа хувийн хэргээр визгүйгээр үндэснийхээ паспорттай зорчиж болно.

2. Онцгой тохиолдолд урилгын гэрчилгээг нутаг дэвсгэрт нь очих Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллагууд, тухайлбал Бүгд Найрамдах Монгол Ард Улсад Нийгмийг аюулаас хамгаалах Яамны байгууллагууд, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсад Дотоод явдлын Яамны байгууллагуудын баталгаа бүхий цахилгаан утсаар орлуулж болно.

3. Урилгын гэрчилгээ болон баталгаа бүхий цахилгаан утсыг нутаг дэвсгэрт нь очих Хэлэлцэн тохиролцогч Талын хэлээр үйлдэнэ.

Урилгын гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн нэг жил, баталгаа бүхий цахилгаан утас нь хүлээн авсан өдрөөс эхлэн гурван долоо хоногийн хугацаанд хүчинтэй байна.

10 дугаар зүйл

1. Харьат улсынхаа нутаг дэвсгэрт байнга суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа харьяат улсынхаа байнгын төлөөлөгчийн газрын ажилтныд дипломат төлөөлөгчийн буюу консулын газраас баталсан урилгаар зочлохдоо визгүйгээр үндэснийхээ паспорттай зорчиж болно. Энэ тохиолдолд, нутаг дэвсгэрт нь очих Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллагаас урилгын гэрчилгээ авах шаардлагагүй.

2. Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохиролцогч Талуудын улс, ардын аж ахуйн барилга байгууламжид ажиллаж байгаа ажилчин, мэргэжилтний гэр бүлийн гишүүд урилгын гэрчилгээ болон баталгаатай цахилгаан утасны аль нэгтэй бол Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт визгүйгээр үндэснийхээ паспорттай нэвтрэн орж болно.

11 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт түр хугацаагаар, гэхдээ 3 сараас доошгүй хугацааны албан ажлаар яваа болон суралцаж буюу эмчлүүлж байгаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн, энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд заасан нөхцөлийн дагуу ойрын төрөл садан /эцэг, эх, нөхөр, эхнэр, хүү охин/, дотны танилаа урьж болно.

2. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт усан онгоц хүлээн авах буюу засварлахтай холбогдсон албан хэргээр түр байгаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн – тэнгисийн болон гол мөрний усан онгоцны багийн гишүүд нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацааг харгалзахгүйгээр ойрын төрөл садан /эцэг, эх, нөхөр, эхнэр, хүү охин/-г зочноор урьж болно.

12 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын иргэнтэй гэрлэсэн Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн болон тэдний насанд хүрээгүй хүүхэд нь шаардлага гарсан тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд заасан нөхцөлийн дагуу хувийн хэргээр зорчиж болно.

13 дугаар зүйл

Хувийн хэргээр зорчиж яваа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн нь урилгын гэрчилгээ, баталгаатай цахилгаанд буюу үндэсний паспортад заасан бөгөөд улсын хил нэвтэрсэн өдрөөс эхлэн тооцогдох хугацааны дотор Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байж болно.

Оршин суух хугацааг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газраас бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу сунгаж болно.

Амрахаар болон эмчлүүлэхээр зорчих

14 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн улс, олон нийтийн байгууллагаас олгосон амрах эрхийн бичгээр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр дэх сувилал болон амралтын газарт очихдоо визгүйгээр үндэснийхээ паспорттай зорчиж болно.

2. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн нутаг дэвсгэрт нь очих Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын Эрүүлийг хамгаалах Яамнаас эмчлэх буюу зөвлөлгөө өгөхөөр хүлээн авахад бэлэн байгаа тухай бичгээр өгсөн баталгааны үндсэн дээр эмчлүүлэхээр буюу эмчийн зөвлөлгөө авахаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт визгүйгээр үндэснийхээ паспорттай нэвтрэн орж болно.

3. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн нь оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч Талын визтэйгээр энэ зүйлийн 1,2-т заасан нөхцөлийн дагуу харьяат улсынхаа нутаг дэвсгэрт амрахаар болон эмчлүүлэхээр зорчиж болно.

Байнга оршин суухаар нэвтрэн орох

15 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суухаар очихдоо нэвтрэн орох виз авна.

Дамжин өнгөрөх

16 дугаар зүйл

1. Харьяат улсынхаа нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрээр дор дурдсан журмаар визгүйгээр дамжин өнгөрч болно:

- албан болон хувийн хэргээр яваа бол очих улсын нэрийг зааж бичсэн, мөн виз авах журамтай улсад бол түүний виз бүхий үндэсний паспорттайгаар;
- жуулчлах зорилгоор яваа бол жуулчлалын бичиг баримт, үндэсний паспорттайгаар;

2. Гуравдахь улсад байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэд нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа улсын иргэнтэй адил нөхцөлөөр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрнө.

3. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын энэхүү зүйлийн 1-д заасан нөхцөлөөр харьяат улсынхаа нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч болно.

Гуравдахь улсад орох, гарах

17 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн гуравдахь улсад зорчих явдлыг нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч Талын дүрмээр зохицуулна.

2. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль алинтай адил утгатай хэлэлцээр бүхий улсад зорчих явдлыг нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч Талын иргэнд хамаарагдах нөхцөлөөр зохицуулна.

18 дугаар зүйл

Гуравдахь улсад байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн, нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа улсын иргэнд хамаарагдах нөхцөлөөр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчиж болно.

Хүүхэд зорчих

19 дүгээр зүйл

Насанд хүрээгүй хүүхэд өөрт нь олгосон үндэсний паспорттайгаар буюу хэрэв паспортад нь бичигдсэн бол эцэг, эх болон түүнийг дагуулж яваа хүний үндэсний паспортаар энэхүү Хэлэлцээрийн заалтын дагуу зорчиж болно. Паспортад бичигдсэн хүүхдийн зургийг тамгаар батална. Долоо хүртэлх насны хүүхдийн зураг эцэг эх буюу дагуулж яваа хүний үндэсний паспортад заавал байх шаардлагагүй.

20 дугаар зүйл

Эцэг эх буюу тэдний аль нэгийг, эсгүүл паспортад нь бичигдсэн өөр хүнийг дагалдан, энэхүү Хэлэлцээрийн 9-11 дүгээр зүйлийн заалтын дагуу зорчиж яваа 16 хүртэлх насны хүүхдээс урилгын гэрчилгээ шаардахгүй. Харин насанд хүрээгүй хүүхэд биеэ даан зорчиж байгаа бол урилгын гэрчилгээтэй байх ёстой.

Бусад заалт

21 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт заагдаагүй тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт визтэй нэвтрэн орно.

22 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэд энэхүү Хэлэлцээрийн заалтын дагуу зорчихдоо олон улсын зорчигчид чөлөөтэй нэвтрэх хилийн боомтоор ямар ч төрлийн хөсгөөр нэвтэрч болно.

23 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талынхаа иргэнийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах буюу нутаг дэвсгэртээ түүний байх хугацааг богиносгох эрхтэй.

Хэлэлцэн тохиролцогч Тал нь нутаг дэвсгэртээ түр байгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын иргэний байх хугацааг богиносгосон тухайгаа түүнийг харьяалах улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт мэдэгдэнэ.

24 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа үндэснийхээ паспортыг үрэгдүүлсэн Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн, энэ тухайгаа нутаг дэвсгэрт нь үндэснийхээ паспортыг үрэгдүүлсэн Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой. Эрх бүхий байгууллага нь үндэсний паспортаа үрэгдүүлсэн тухай мэдэгдсэнийг баталсан магадлагааг тухайн иргэнд олгоно. Дипломат төлөөлөгчийн буюу консулын газар нь үрэгдсэн паспортын оронд үндэсний үндэсний паспортыг шинээр олгоно. Шинэ паспорттай гарах явдлыг нутаг дэвсгэрт нь паспорт үрэгдсэн Хэлэлцэн тохиролцогч Талын дүрмээр зохицуулна.

25 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллагууд үндэсний паспорт, урилгын гэрчилгээ, тэдгээрт хийх бичлэг болон дарах тамга тэмдгийн загварыг солилцоно. Хэрэв паспорт, урилгын гэрчилгээ болон тамга тэмдэгийг шинэчилсэн буюу өөрчилсөн бол энэ тухайгаа Хэлэлцэн тохиролцогч Талууд 30-аас доошгүй хоногийн дотор бие биедээ мэдээлж, тэдгээрийн загварыг харилцан шилжүүлнэ.

26 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллагууд үндэсний паспортыг бүртгэх, бүртгэлийг сунгах, паспортад хийх тэмдэглэл, орох буюу гарах виз олгох, визэд өөрчлөлт, засвар оруулах, түүнчлэн үндэсний паспортаа

үрэгдүүлсэн тухай мэдэгдсэн тодорхойлолт олгохдоо татвар болон бусад хураамж авахгүй.

27 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шаардлагатай үед харилцан мэдээлэл солилцож, зөвлөлдөж байна.

28 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

29 дүгээр зүйл

Онцгой тохиолдолд /гоц халдварт өвчин, байгалийн гамшиг гэх мэт/ Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэг нь өөрийн нутаг дэвсгэрт нэвтрэн орохыг түр хязгаарлаж болно. Хэлэлцэн тохиролцогч Талууд нь нутаг дэвсгэртээ нэвтрэн ороход хязгаарлалт тогтоосон буюу түүнийг хүчингүй болгосон тухайгаа тийм шийдвэр гаргаснаас хойш 24 цагаас хэтрүүлэхгүйгээр бие биедээ дипломат шугамаар мэдээлж байх ёстой.

Төгсгөлийн заалт

30 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийг зохих журмын дагуу биелүүлэхээ Талууд баталж нот солилцсоноос хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээрийг тодорхой бус хугацаагаар байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэг нь түүнийг цуцлах саналтай байгаагаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдэх хүртэл хүчин төгөлдөр байна. Цуцлах тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс 60 хоногийн дараа энэхүү Хэлэлцээр хүчингүй болно.

31 дүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1971 оны нэгдүгээр сарын 26-ны өдөр байгуулсан “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын иргэд харилцан визгүйгээр зорчих журмын тухай Хэлэлцээр” хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг 1979 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Москва хотноо монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд уг хоёр эх хувь нь адил хүчинтэй байна.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД
НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**ИРГЭД ХАРИЛЦАН ВИЗГҮЙ ЗОРЧИХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ
БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД 1979 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР
САРЫН 20-НД БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦЭЭРИЙН
ПРОТОКОЛ**

I

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын нутаг дэвсгэрт түр оршин суугаа буюу түүний нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч буй Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын иргэд хэрэв үндэсний паспорт нь гурав дахь улсад нэвтрэх хүчинтэй байвал тэдгээр улсад зорчих эрхтэй.

Хэлэлцэн тохиролцогч Талуудын үндэсний паспорт нь хэрэв түүнд очих улсын нэрийг зааж, хязгаарласан тэмдэглэл /тэмдэг/ хийгээгүй бол аль ч улсад зорчих эрх олгоно.

Хэлэлцэн тохиролцогч Талуудын хязгаарласан тэмдэглэл /тэмдэг/ бүхий үндэсний паспорт нь зөвхөн тэмдэглэл /тэмдэг/-д дурдагдсан улсад зорчих эрх олгоно.

II

1. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн нь харьяат улсынхаа нутагт түр байхдаа гуравдахь улсад зорчих бол энэ тухай зөвшөөрлийг байнга оршин суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын зөвшлөөр авна.

2. Энэ зүйлийн 1-д заасан иргэн Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль алинтай нь адил утгатай хэлэлцээр байгуулсан улсад зорчихдоо дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын зөвшил авах шаардлагагүй.

III

1. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын эрх бүхий байгууллага нь шаардлагатай гэж үзвэл өөрийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын иргэнд, хэрэв тэр нь гуравдахь улсад албан хэргээр томилогдсон байнга оршин суугаа улсын иргэний гэр бүлийн гишүүний хувьд явж байгаа бол түүнд дипломат, албан болон энгийн гадаад паспорт олгож болно.

Энэ тохиолдолд үндэсний паспортыг уг иргэнийг бүртгэсэн дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт хадгалуулахаар өгнө.

2. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын иргэний гэр бүлийн гишүүн- Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн нь харьяат улсынхаа нутаг дэвсгэрт үндэснийхээ паспорттай нэвтрэн орно.

Уг иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын дипломат паспорт бүхий иргэний гэр бүлийн гишүүний хувьд зорчиж байгаа бол түүний үндэсний паспортад байнга оршин суугаа орны эрх бүхий байгууллага “Д” гэсэн тэмдэглэл /тэмдэг/ хийх бөгөөд тийм паспорттай хүн улсын хил нэвтрэхдээ дипломат паспорт эзэмшигчийн нэг адил гаалийн эрх ямба эдэлнэ.

IV

Улс, олон нийтийн байгууллагын хоорондын солилцооны хүрээнд нэг буюу хэсэг иргэд зорчих талаар хүлээн авагч талын холбогдох байгууллагатай урьдчилан тохиролцож байх болно.

V

Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохиролцогч Талын визтэй бол хувийн хэргээр харьяат улсдаа урилгын гэрчилгээгүйгээр үндэснийхээ паспорттай зорчиж болно. Энэхүү заалт Хэлэлцэн тохиролцогч Талуудын аль нэгний харьяат-гэр бүлийн гишүүдэд нэгэн адил хамаарна.

VI

17 дугаар зүйлийн 2 нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын иргэнтэй гэрлэсэн Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэн болон түүний гэр бүлийн гишүүдэд хамаарна.

VII

1. Харьяат улсынхаа нутаг дэвсгэрт байнга оршин суудаг бөгөөд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу зорчих Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэний үндэсний паспортад түүний байнга оршин суугаа орны эрх бүхий байгууллагууд:

- Албан хэргээр болон солилцооны хүрээнд явахад /4 дүгээр зүйлийн 1,2 болон 5 дугаар зүйлийн 1-ийн дагуу/ “AB” гэсэн тэмдэглэл хийх бөгөөд харин түүнийг дипломат болон албан паспортад хийхгүй;
- Сувилал болон амралтын газарт явах /14 дүгээр зүйлийн 1-ийн дагуу/, түүнчлэн эмчлүүлэх, эмчийн зөвлөлгөө авахаар явахад /14 дүгээр зүйлийн 2-ын дагуу/ “AC” гэсэн тэмдэглэл хийнэ;
- Байнгын төлөөлөгчийн газруудын ажилтны зочноор явахад /10 дугаар зүйлийн 1-ийн дагуу/ “AO” гэсэн тэмдэглэл хийнэ;

“AO”, “AB”, “AC” тэмдэглэлийг гарч явах зөвшөөрлийг уг иргэнд олгосон Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллагын тамгаар батална.

2. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа бөгөөд 4 дүгээр зүйлийн 3, 5 дугаар зүйлийн 2, 10 дугаар зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 3-ын дагуу харьяат улсынхаа нутаг дэвсгэрт зорчих Хэлэлцэн тохиролцогч нэг Талын иргэний паспортад түүний байнга оршин суугаа орны эрх бүхий байгууллага мөнхүү тэмдэглэлийг хийнэ.

VII

Энэхүү Протокол хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн 1971 оны нэгдүгээр сарын 26-ны өдөр байгуулсан “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын иргэд харилцан визгүйгээр зорчих журмын тухай Хэлэлцээр”-ийн 1971 оны нэгдүгээр сарын 26-ны өдрийн Нэмэлт

Протокол болон 1973 оны аравдугаар сарын 4-ний өдрийн Нэмэлт Протокол тус тус хүчингүй болно.

IX

Энэхүү Хэлэлцээр нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсад түр байрлаж байгаа зөвлөлтийн цэргийн бүрэлдэхүүнд багтах цэргийн албан хаагчид, ажилчид, албан хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд үл хамаарах бөгөөд тэдний нэвтрэн орох, оршин суух болон шилжин явах журмыг тусгай гэрээ, хэлэлцээрээр тодорхойлно.

X

Хэлэлцэн тохиролцогч Талууд нь энэхүү Протоколыг нийтлэхгүйгээр тохиролцов.

Энэхүү Протокол нь иргэд харилцан визгүй зорчих нөхцөлийн тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хоорондын 1979 оны арван хоёрдугаар сарын 20-нд байгуулсан Хэлэлцээрийн салшгүй хэсэг бөгөөд Хэлэлцэн тохиролцогч хоёр Талын эрх бүхий байгууллагууд зөвшөлцсөнөөр түүний заалтуудад дипломат шугамаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Энэхүү Протоколыг Москва хотноо 1979 оны арван хоёрдугаар сарын 20-ны өдөр монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд уг хоёр эх хувь нь адил хүчинтэй байна.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД
НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг